



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Гавшгай ус" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/23/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: А.Гэрэлмаа Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
4. Аудитын тайлан	14
4.1. Ерөнхий зүйл	14
4.2. Материаллаг байдал.....	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	15
4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18
5.1 Залруулга	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ГАВШГАЙ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА Б.ҮҮРДМӨНХ ТАНАА

2024.03.15 № СЭА-2024/23/НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн нөлөөг эс тооцвол “Гавшгай ус” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 27,653.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Гавшгай ус” ААТҮГ нь аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу тайлант онд үндсэн хөрөнгийн барилга, худаг усалтын системд дахин үнэлгээг Сор үнэлэмж ХХК-иар хийлгэснээр үндсэн хөрөнгө 2,269,733.8 мянган төгрөгөөр буурсан байна.

СЭА-2024/23/НА-СТА-ОНА

3

018020326

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын шимтгэлийн 1,132,001.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүйгээс нийгмийн даатгалын сангаас олговол зохих 6,779.2 мянган төгрөгийн ХЧТА тэтгэмж, 6,358.6 мянган төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 1,951.6 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж зэрэг нийт 17,709.0 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6 дахь “Ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж төлөх” гэсэн заалтын дагуу үйлдвэрийн газраас төлсөн нь алдагдлын хэмжээнд нөлөөлж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Гавшгай-ус ” ААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	75,670,153.55	8,790,143.45
1.1.2	Дансны авлага	1,501,484,537.49	1,691,649,826.59
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,546,225.90	3,546,225.90
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	253,566,634.66	285,239,282.98
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,800,000.00	2,800,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,837,067,551.60	1,992,025,478.92
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,211,203,417.50	3,747,292,425.14
1.2.2	Биет бус хөрөнгө	845,968,577.50	842,264,959.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,057,171,995.00	4,589,557,384.14
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,894,239,546.60	6,581,582,863.06
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	110,438,749.02	156,866,592.63
2.1.1.2	Цалингийн өглөг	6,090,654.28	24,632,937.86
2.1.1.3	Татварын өр	634,450,941.09	714,971,234.93
2.1.1.4	НДШ-ийн өглөг	995,786,376.58	1,132,001,049.26
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,746,766,720.97	2,028,471,814.68
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,746,766,720.97	2,028,471,814.68
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	294,374,941.69	294,374,941.69
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,296,382,891.35	5,026,649,071.80
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,556,423,439.00	1,556,423,439.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,999,708,446.41)	(2,324,336,404.11)
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,147,472,825.63	4,553,111,048.38
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,894,239,546.60	6,581,582,863.06

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,732,492,549.38	1,741,471,932.92
2	Борлуулалтын өртөг	1,628,460,232.06	1,943,964,386.41
3	Нийт ашиг (алдагдал)	104,032,317.32	(202,492,453.49)
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	18,613,896.55	53,008,847.63
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	146,687,963.93	145,673,100.99
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	68,416,612.57	28,685,990.25
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(92,458,362.63)	(323,842,697.10)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(92,458,362.63)	(323,842,697.10)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(92,458,362.63)	(323,842,697.10)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(92,458,362.63)	(323,842,697.10)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	(1,907,250,083.78)	7,239,931,188.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
3	Залруулсан үлдэгдэл	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	(1,907,250,083.78)	7,239,931,188.26
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(92,458,362.63)	(92,458,362.63)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	(1,999,708,446.41)	7,147,472,825.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
11	Залруулсан үлдэгдэл	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	(1,999,708,446.41)	7,147,472,825.63
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(323,842,697.10)	(323,842,697.10)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт				(785,260.60)	(785,260.60)
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(2,269,733,819.55)			(2,269,733,819.55)
17	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	1,556,423,439.00	(2,324,336,404.11)	4,553,111,048.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,468,036,437.34	1,634,735,761.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,458,036,437.34	1,569,323,378.34
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		65,357,725.20
1.1.6	Бусад мөнгөн орлого	10,000,000.00	54,658.43
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,422,509,631.38	1,676,615,772.07
1.2.1	Ажиллагчдад төлсөн	661,189,377.07	629,413,808.51
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,753,643.00	72,874,081.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	66,108,609.00	122,012,667.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	317,240,266.36	336,892,861.34
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	109,505,252.81	319,542,442.50
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,933,545.53	338,395.88
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	135,532,728.69	127,163,472.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	39,246,208.92	68,378,042.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	45,526,805.96	(41,880,010.10)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	28,479,999.98	25,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,479,999.98	25,000,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(28,479,999.98)	(25,000,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,046,805.98	(66,880,010.10)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	58,623,347.57	75,670,153.55
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,670,153.55	8,790,143.45

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого /НӨАТ-гүй/	м/төг	1,988,068.8	1,794,480.8	(193,588.0)	(0.1)
	Үйл ажиллагааны орлого	м/төг		1,741,471.9	1,741,471.9	-
	Татаас санхүүжилтийн орлого	м/төг		52,954.2	52,954.2	-
	Бусад орлого	м/төг		54.7	54.7	-
2	Нийт зарлагын дүн	м/төг	1,926,473.8	2,089,637.5	163,163.7	0.1
3	Цалин хөлс	м/төг	725,038.8	789,767.6	64,728.8	0.1
4	НДШ-ийн зардал	м/төг	118,012.9	129,510.6	11,497.7	0.1
5	Бараа үйлчилгээний бусад зардал	м/төг	1,083,422.1	1,170,359.3	86,937.2	0.1
	Цахилгаан	м/төг	368,353.5	408,442.7	40,089.2	0.1
	Дулаан	м/төг	19,150.4	31,201.0	12,050.6	0.6
	Нүүрс	м/төг	66,293.6	95,626.6	29,333.0	0.4
	Түлш, шатахуун	м/төг	43,879.8	50,979.5	7,099.7	0.2
	Засвар үйлчилгээний зардал	м/төг	179,454.6	134,297.5	(45,157.1)	(0.3)
	Бичиг хэрэг	м/төг	2,168.3	3,063.1	894.8	0.4
	Албан томилолт	м/төг	3,948.2	9,993.0	6,044.8	1.5
	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлт	м/төг	17,141.4	17,140.8	(0.7)	-
	Лабораторийн зардал	м/төг	1,565.8		(1,565.8)	(1.0)
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	м/төг	297,608.5	336,022.0	38,413.5	0.1
	Хангамжийн материалын элэгдлийн зардал	м/төг		31,020.7	31,020.7	-
	Шуудан холбооны зардал	м/төг		2,427.3	2,427.3	-
	Түрээсийн зардал	м/төг		8,450.0	8,450.0	-
	Тээврийн зардал	м/төг		3,510.0	3,510.0	-
	Сургалт	м/төг	1,563.9	2,380.0	816.1	0.5
	НӨАТ, ХХОАТ, Суутган	м/төг	31,905.8		(31,905.8)	(1.0)
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	м/төг	37,318.0	29,189.9	(8,128.1)	(0.2)
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	м/төг	2,500.0	2,455.6	(44.4)	(0.0)	
Даатгалын зардал	м/төг	2,021.0		(2,021.0)	(1.0)	
Бусад зардал	м/төг	8,549.3	4,159.8	(4,389.6)	(0.5)	
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	м/төг	61,595.0	(295,156.7)	(356,751.7)	(5.8)
7	Орлогын албан татвар	м/төг			-	
8	Үйл ажиллагааны бус зардал	м/төг	45,231.2	28,686.0	(16,545.2)	(0.4)
	Үйл ажиллагааны бус бусад зардал	м/төг	22,493.9	19,098.5	(3,395.4)	(0.2)
	Ажиллагсдын нийгмийн зардал	м/төг	22,737.3	9,587.5	(13,149.8)	(0.6)
9	Татварын дараах ашиг, алдагдал	м/төг	16,363.8	(323,842.7)	(340,206.5)	
10	Хөрөнгө оруулалт	м/төг	16,360.8	16,000.0	360.8	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Гавшгай ус” ААТҮГ нь *“Хөтөл тосгоны ард иргэд, аж ахуйн нэгжийг унд, ахуйн цэвэр усаар тасралтгүй, найдвартай хангах”* гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Гавшгай ус” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Ус цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Номгон тосгоны уурын зуух,
- Гадаад худалдаа гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Гавшгай Ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Гавшгай Ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор “Гавшгай Ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д *“Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”*, 21 дүгээр зүйл *“Аймгийн чиг үүрэг”*, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь *“харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”* гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон, гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Гавшгай ус” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Гавшгай ус” ААТҮГ нь захирлын 2022 оны 08 сарын 25-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Гавшгай ус” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	75,670.2	8,790.2	(66,880.0)
Авлага	1,501,484.5	1,691,649.8	190,165.3
Татвар, НДШ-ийн авлага	3,546.2	3,546.2	-
Бараа материал	253,566.6	285,239.3	31,672.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,800.0	2,800.0	-
Үндсэн хөрөнгө	7,057,172.0	4,589,557.3	(2,467,614.7)
Нийт хөрөнгийн дүн	8,894,239.5	6,581,582.8	(2,312,656.7)
Өр төлбөр	1,746,766.7	2,028,471.8	281,705.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,296,382.9	5,026,649.1	(2,269,733.8)
Эздийн өмч	(148,910.1)	(473,538.1)	(324,628.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,894,239.5	6,581,582.8	(2,312,656.7)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 66,880.0 мянган төгрөгөөр буурсан нь 1,634,735.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,701,615.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,691,649.8 мянган төгрөг болж 190,165.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн нэгжээс болон оршин суугчдаас авах үйлчилгээний төлбөрийн авлага өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт авлагын 55.1 хувийг буюу 932,874.8 мянган төгрөгийг оршин суугчдаас авах усны, 39.9 хувийг буюу 674,414.0 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжээс авах усны, 2.8 хувийг буюу 47,204.5 мянган төгрөгийг ажиллагсдаас авах, 1.5 хувийг буюу 25,652.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах, 0.5 хувийг буюу 8,774.4 мянган төгрөгийг цалингийн, 0.2 хувь буюу 2,730.1 мянган төгрөгийг дараа тайлангийн авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч тодорхойгүй, насжилт өндөртэй ажиллагсдаас *ажлаас гарсан* авах 47,204.5 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 25,652.0 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 285,239.3 мянган төгрөг болж 31,672.7 мянган төгрөгөөр өссөн нь 470,227.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 438,554.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,589,557.3 мянган төгрөг болж 2,467,614.7 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 22,727.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгийн барилга, худаг усалтын системд дахин үнэлгээг Сор үнэлэмж ХХК-иар хийлгэснээр үндсэн хөрөнгийн үнэлгээ 2,269,733.8 мянган төгрөгөөр буурсан болон Сэлэнгэ цэнгэг ус ААТҮГ-т балансаас балансад 1,570.0 мянган төгрөгийн хатаах шүүгээг үлдэгдэл өртгөөр нь шилжүүлсэн зэргээс тус тус шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,028,471.8 мянган төгрөг болж 281,705.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Нийт өр төлбөрийн 55.7 хувийг буюу 1,130,049.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 35.3 хувийг буюу 716,922.4 мянган төгрөгийг татварын, 7.7 хувийг буюу 156,866.6 мянган төгрөгийг дансны өр төлбөр, 1.2 хувийг буюу 24,632.9 мянган төгрөгийг цалингийн өр төлбөр эзэлж байна.

Дансны өр төлбөрийн 55.7 хувийг буюу 130,089.1 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжид өгөх бараа үйлчилгээний, 9.5 хувийг буюу 14,872.2 мянган төгрөгийг ажиллагсдад өгөх, 3.7 хувийг буюу 5,788.3 мянган төгрөгийг хувь хүмүүст өгөх, 2.0 хувийг буюу 3,064.9 мянган төгрөгийг оршин суугчдад өгөх, 1.9 хувийг буюу 3,052.1 мянган төгрөгийг дараа тайлангийн өр төлбөр тус тус эзэлж байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй. “Гавшгай ус” ААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж Сэлэнгэ аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Тайлант оны орлогыг 1,988,068.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,988,068.8 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,794,480.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,118,323.5 мянган төгрөгийн зардал гарган, 323,842.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 1,794,480.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөөг 9.7 хувиар тасарсан нь гол харилцагч болох Цемент шохой компанид нийлүүлж буй борлуулалтаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардал 2,118,323.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөсөн зардал 6.1 хувиар хэтэрсэн нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2023 оны 1 сарын 1-нээс 550.0 мянган төгрөг болж нэмэгдсэн, шугам хоолой хуучирч муудсанаас гэмтэл их гарч засварын ажил хийгдсэн, конторын барилгын их засварыг өөрсдийн хүчээр хийж илүү цагийн нэмэгдэл хөлс бодогдсон зэргээр цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэтэрсэн, тайлант онд дулааны болон шатахуун, нүүрсний үнэ өссөн зэргээс голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын

хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Гавшгай ус” ААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,843,564.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 27,653.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Гавшгай ус” ААТҮГ нь мэдээлбэл зохих 26 төрлийн 157 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож, 17 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроож мэдээлсэн:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт - 9 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан - 1 удаа,
- Байгууллагын батлагдсан төсөв - 1 удаа,

Огт мэдээлээгүй:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт - 3 удаа,
- Дараа жилийн зорилтот түвшин - 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө - 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны тайлан – 1 удаа,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг - 4 удаа,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл - 4 удаа,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 3 удаа гэх мэт.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд худалдан авах босго үнээс давсан 54,335.7 мянган төгрөгийн шатахууныг “Тэс петролиум” ХХК-тай, харьцуулалтын аргын босго үнээс давсан 105,189.2 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг авлагадаа суутгуулан тооцдог гэх шалтгаанаар “Хөтөл энерги дулаан” ХХК-тай тус тус шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1: “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг”, 2: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах албан шаардлага хүргүүлэх .

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Гавшгай ус” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Засвар үйлчилгээний зардлыг 45,157.13 мянган төгрөгөөр,
- Даатгалын зардлыг 2,021.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 8,128.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэн,
- Хандив тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргаагүй, өөрийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл болон согтууруулах ундаа худалдан авахыг хориглох зэргээр хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2023 оны 11 дүгээр 02-ны өдрийн 22/59 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 37,808.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 182.8 мянган төгрөгөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 37,625.2 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	182.8	1	182.8	100.0
Албан шаардлага	5	37,625.2	5	37,625.2	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	7	37,808.0	7	37,808.0	100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

- Тус ААТҮГ нь үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байгаа нь удирдлага, менежментийн үйл ажиллагаатай холбоотой эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх эсэхийг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.
- Санхүүгийн тайланд тайлагнагдсан 1,691,649.8 мянган төгрөгийн авлага, 2,028,471.8 мянган төгрөгийн өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах болон шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

5. Аудитын илрүүлэлт :

5.1 Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой нийт 2,414,454.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 52,954.2 мянган төгрөгийн "Орон сууцны хорооллын инженерийн шугам"-ыг үндсэн хөрөнгөөр бүртгэлгүй, шууд зардлаар тайлагнасан,
- Тайлант онд хийгдсэн 63,245.0 мянган төгрөгийн конторын их засварын ажлыг капиталжуулалгүй шууд зардлаар тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд 1,951.2 мянган төгрөгийн татварын өр төлбөрийг ногдол ашгийн өр төлбөрөөр тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг 25,000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээг 2,269,733.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Үндсэн хөрөнгийн бүртгэлд тайлант онд ОНӨГ-ын зөвшөөрлөөр балансаас балансад шилжүүлсэн 1,570.0 мянган төгрөгийн хатаах шүүгээг зарлага гаргалгүй элэгдэл тооцсон гэх мэт.

Аудитаар нийт **398,777.0** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлснээс 334,363.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 64,413.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

1. Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Томилолтын хуудас, удирдамж, тайлан, унааны төлбөрийн баримтгүйгээр 7,723.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон,
- Холбогдох албан тушаалтны шийдвэр, илүү цаг ажилласныг дэмжих тодорхойлолт, бүртгэлгүйгээр 5 ажилтанд 2,797.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс бодож олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Боловсруулж, батлуулсан 2023 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг 193,588.0 мянган төгрөгөөр тасалж, зардлыг нийт 130,254.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан “*Гавшгай ус*” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө” -г тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого зарлагын төлөвлөгөөг тооцоо судалгаан дээр үндэслэн бодитоор төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 64,413.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “*Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх*” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агуй		Тоо	Дүн
Барилгын их засварын ажлыг капиталжуулалт үй шууд зардлаар тайлагнасан	1	63,245.0			1	63,245.0	1	63,245.0				
Шугам сольсон ажлыг хөрөнгөөр бүртгээгүй, шууд зардалд тайлагнасан	1	52,954.2			1	52,954.2	1	52,954.2				
Татварын өрийг буруу тайлагнасан	1	1,951.2			1	1,951.2	1	1,951.2				
МГТайланд үндсэн хөрөнгийн худалдан авалтыг дутуу илэрхийлсэн	1	25,000.0			1	25,000.0	1	25,000.0				
Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээг илэрхийлээгүй	1	2,269,733.8	1	2,269,733.8			1	2,269,733.8				
Шилжүүлсэн хөрөнгийг зарлагдаагүй	1	1,570.0			1	1,570.0	1	1,570.0				
Дүн	6	2,414,454.2	1	2,269,733.8	5	144,720.4	6	2,414,454.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	10,520.4			1	10,520.4							
Төлөвлөсөн орлогыг дутуу төвлөрүүлж, зардлыг хэтрүүлсэн	1	323,842.7			1	323,842.7							
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	64,413.9					1	64,413.9					
Дүн	3	398,777.0			2	334,363.1	1	64,413.9					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг 11 удаа хоцроосон, 17 мэдээллийг огт мэдээлээгүй	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	2				1		1	